



Байгаль Орчин,
Аялал Жуулчлалын
Яам



Аялал Жуулчлалын
Хөгжлийн
Төв



Монголын Үндэсний
Худалдаа Аж Үйлдвэрийн
Танхим



Аялал Жуулчлалын
Боловсрол, Хөгжлийн
Нийгэмлэг

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ



ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Таны амар амгаланг айлтгая!

Аялал жуулчлалын бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, уялдаа холбоог сайжруулах зорилго бүхий салбарын бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн Аялал жуулчлалын зөвлөл МҮХАҮТ-ын дэргэд үйл ажиллагаа явуулдаг билээ.

Дэлхий нийтэд тархсан цар тахлын нөлөөгөөр бизнесийн салбарууд их хэмжээний эдийн засгийн алдагдлыг хүлээж, тэр дундаа олон улсын зорчих хөдөлгөөн хязгаарлагдсантай холбоотойгоор аялал жуулчлалын салбар 2020-2021 оны хугацаанд 3 их наяд гаруй төгрөгийн алдагдал хүлээж, тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 1,600 гаруй аж ахуйн нэгжүүд, 88,000 гаруй ажлын байр эрсдэлд ороод 2 жилийн нүүрийг үзэж байна.

Иймд цар тахлын хязгаарлалтын арга хэмжээнүүд аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлсөн, цаашид бизнесээ сэргээж үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тулгарч буй саад бэрхшээл, түүнийг даван туулах гарц шийдэл, төрөөс ямар төрлийн дэмжлэг хэрэгжүүлэх нь тухайн салбарын онцлогт тохирсон бодит дэмжлэг болох тухайд тодруулан, цаашид аялал жуулчлалын салбарын бодлого боловсруулах, стратеги төлөвлөгөө гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно.

Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан БОАЖЯ, АЖХТ, АЖБХН, төрийн бус байгууллагууд, судалгаанд оролцсон тур оператор, жуулчны бааз, амралтын газар, зочид буудал, ресторан зэрэг байгууллагуудад гүн талархал илэрхийлж ажлын өндөр амжилт хүсье.

МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал Жуулчлалын Зөвлөлийн дарга Б. Барсболд

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД

Б.Барсболд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх
Аялал Жуулчлалын Зөвлөлийн дарга

Д.Батболд, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн гүйцэтгэх
захирал

Д.Мөнхтөмөр, Хаппи сити групп ХХК-ийн аялал жуулчлал хариуцсан захирал,
судлаач

Д.Бадрах, Шийдэл АЖБТөв ТББ-ын зөвлөх

С.Мөнхнасан, МҮИС-ийн АЖГХС-ийн захирал дэд проф

Т.Чулуунцэцэг, Авид Зам ХХК-ийн захирал

Н.Адьяаболд, Нью Майлстөн ХХК-ийн захирал

Ц.Ууганбаяр, Вандер Монголия Эдвэнчирс ХХК-ийн гүйцэтгэх захирал, судлаач

Ш.Жамина, Судалгааны ажилтан

СУДАЛГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Монголын Аялал Жуулчлалын Холбоо

Монголын Зочид Буудлын Холбоо

Аялал Жуулчлалын Боловсрол Хөгжлийн Нийгэмлэг

Монголын Тур Операторуудын Холбоо

Монголын Мастер Тогооч Нарын Холбоо

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

Удиртгал.....	5
I. Судалгааны зорилго, арга зүй, түүвэрлэлт.....	6
Зорилго.....	6
Арга зүй, түүвэрлэлт.....	6
II. Бизнес т үзүүлсэн нөлөө.....	8
III. Бизнесээ сэргээхэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэг.....	11
IV. Ерөнхий үр дүн.....	13
Цар тахлын үеийн аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын нэгдсэн матриц.....	16
V. Дэд салбаруудаарх дэлгэрэнгүй тайлан.....	17
Аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор.....	17
Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудал.....	23
Зочид буудал.....	31
Ресторан.....	40

Удиртгал

Монгол Улсын аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд чухал нөлөөтэй, үйлчилгээний худалдааны экспортын 40 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг эдийн засгийн олон салбарын оролцогч талуудтай нягт хамтран ажилладаг бизнесийн онцлог салбар юм.

Олон улсын судалгаагаар аялал жуулчлалын салбарын Монгол Улсын ДНБ-д үзүүлж байгаа шууд үр нөлөө буюу эзлэх хувь хэмжээ нь 2018 онд 11.8% байсан ба энэ үзүүлэлт 2020 онд гэхэд 20% хүрэх боломжтой гэжээ¹. Мөн дотоодод хийсэн судалгаа, статистик үзүүлэлтүүдийг авч үзвэл 2018 оны байдлаар аялал жуулчлалын салбарын орлого нь сүүлийн 5 жилд дунджаар 20%-иар тогтмол өссөн² дүнтэй байв. Түүнчлэн 2019 он ба цар тахлын өмнөх үед энэхүү салбар нь нийт 88.7 мянга гаруй хүнийг ажлын байраар хангаж, 605.5 сая ам.долларын орлого оруулсан ба энэ нь ДНБ-ний 6.5%-ийг бүрдүүлж байсан³ байна. Иймээс аялал жуулчлалын салбарын онцлогт тохирсон зохистой бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, салбарын аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг үзүүлэх нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх томоохон боломжийг олгох, төлбөрийн тэнцлийг сайжруулах чухал ач холбогдолтой.

Цар тахлын нөлөөгөөр бизнесийн бүх салбарууд амаргүй сорилтуудтай тулж, цар тахлын үеийн шинэ хэвийн байдалтай үйл ажиллагаагаа уялдуулах, бизнесээ сэргээх, цаашид тасралтгүй үйл ажиллагаагаа явуулахаар аж ахуйн нэгжүүд бүх хүчин чадлаа дайчлан ажиллаж байна. Цар тахлын нөлөө хамгийн хүндээр туссан салбаруудын нэг нь аялал жуулчлалын салбар байв. 2020 онд ази, номхон далайн бүс нутгийн орнуудын аялал жуулчлалын салбарын орлого 1.6 их наяд ам.доллар ба 53.7%-иар буурч, салбарын ажиллах хүчний тоо 34.1 сая хүн ба 18.4%-иар буурсан¹ байна. Монгол улсын хувьд 2020 онд ирсэн жуулчдын тоо 2019 онтой харьцуулахад 89.4%-иар буурсан бол 2021 онд ирсэн жуулчдын тоо 33.1 мянга болж 2019 онтой харьцуулахад 94.3%-иар буурсан³ байна. Иймд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд бизнесээ сэргээхэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэгийг тодруулах, цаашлаад тооцоо судалгаатай бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, нэгдсэн стратеги гаргах хэрэгцээ шаардлага байгаа юм. Мөн Монгол Улсын аялал жуулчлалын гол дэд салбаруудыг хамруулсан, тухайн дэд салбарын онцлогийг харгалзан үзсэн, цар тахлын нөлөөллийг үнэлсэн судалгааны ажил хомс байгаа тул МҮХАҮТ-ын Эдийн засгийн судалгааны институтээс МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөлийн санаачилгаар энэхүү түүвэр судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажил нь үндсэн 5 бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын зорилго, арга зүй, түүвэрлэлтийн талаар авч үзлээ. Хоёрдугаар бүлэгт цар тахлын хязгаарлалтын арга хэмжээнүүд нь аялал жуулчлалын салбарын бизнесийн үйл ажиллагаа, орлогын хэмжээ, ажлын байрны тоонд хэрхэн нөлөөлснийг тодорхойлохыг зорилго. Гуравдугаар бүлэгт аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчид бизнесээ

¹ WTTC (World Travel & Tourism Council) судалгаа

² БОАЖЯ-ны танилцуулга

³ Үндэсний статистикийн хороо

сэргээж, тасралтгүй үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл, цаашид шаардагдах дэмжлэгийн арга хэмжээг тодруулав. Дөрөвдүгээр бүлэгт нэгдсэн ерөнхий үр дүнг тусгасан бол тавдугаар бүлэгт аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг гол дэд салбар бүрийн хувьд цар тахал бизнест хэрхэн нөлөөлсөн тухай дэлгэрэнгүй тайлангуудыг нэгтгэн оруулсан болно.

I. Судалгааны зорилго, арга зүй, түүвэрлэлт

Зорилго

Энэхүү түүвэр судалгааны үндсэн зорилго нь цар тахлын хязгаарлалтын арга хэмжээнүүд аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлсөн, засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй байсан эсэх, цаашид бизнесээ сэргээж үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тулгарч буй бэрхшээл, төрөөс ямар төрлийн дэмжлэг хэрэгжүүлэх нь тухайн салбарын онцлогт тохирсон бодит дэмжлэг болох тухайд тодруулан, цаашид аялал жуулчлалын салбарын бодлого боловсруулах, стратеги төлөвлөгөө гаргахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг гол салбар бүрийн хувьд (i) Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээний нөлөөгөөр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, орлого, ажлын байранд орсон өөрчлөлт, (ii) Бизнесээ сэргээхэд тулгарч буй гол бэрхшээлүүд (iii) Бизнесээ сэргээхэд бизнес эрхлэгчдийн зүгээс төрөөс ямар төрлийн дэмжлэгүүд шаардлагатай байгааг тодорхойлох зорилгыг дэвшүүллээ.


Арга зүй, түүвэрлэлт

Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө түүвэр судалгааг гүйцэтгэхдээ тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашиглан, статистик шинжилгээ, харьцуулалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудаар SPSS болон R програм хангамжийн тусламжтай үр дүнг боловсруулав. Судалгааны асуулгыг олон улсад хийгдсэн ижил төстэй судалгааны асуулгууд болон МҮХАҮТ-ын цар тахлын нөлөөг судалсан судалгааны асуулга, аргачлал дээр үндэслэн тухайн дэд 4 салбарын онцлогт тохируулан боловсруулав.

Түүврийн хамрах хүрээ нь аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг гол дэд салбарууд, үүнд: 1) аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор, 2) жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудал, 3) зочид буудал, 4) ресторан гэсэн дөрвөн салбаруудын аж ахуйн нэгжүүдээс бүрдэнэ. Судалгааг 2021 оны 12 сарын 7-оос 2022 оны 1 сарын 26 өдрүүдэд явуулж, нийт 188 аж ахуйн нэгжийн удирдах түвшний албан тушаалтныг хамруулав. Судалгааны түүврийн нэгжийн эх олонлогийн хэмжээ, итгэх завсар, стандарт хазайлт зэрэг үзүүлэлтүүдэд тулгуурлан статистик ач холбогдол, төлөөлөх чадварыг харгалзан түүврийн тоог тооцоолон гаргаж судалгааг явуулсан болно.

Судалгааны оролцсон аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нарийвчлан авч үзвэл 48.4% нь Улаанбаатар хот, 51.6% нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчид байна. Бизнесийн гол үйл ажиллагааны чиглэлээр ангилан харвал 43.6% нь тур оператор, 32.4% нь жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудал, 19.7% нь зочид буудал, 4.3% нь ресторан байна. Нийт судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдийн 66% нь 300 сая хүртэлх жилийн орлоготой бичил аж ахуй нэгжүүд, 27.3% нь 301 саяас 2.5 тэрбум төгрөгийн орлоготой жижиг, дунд аж ахуй нэгжүүд, 6.6% нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой томоохон аж ахуй нэгжүүд байгаа бөгөөд 53% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан харьцангуй тогтворжсон аж ахуй нэгжүүд хамрагджээ. Мөн ажилчдын тооны бүлгээр ангилан харвал 74% нь 10 хүртэлх ажилтантай, 26% нь 11-200 хүртэлх ажилтантай байна.

Зураг 1: Судалгаанд оролцогчдын мэдээлэл




II. Бизнес үзүүлсэн нөлөө

Аялал жуулчлалын салбар нь олон салбарын бизнес эрхлэгчид оролцдог онцлог салбар юм. Иймд судалгааны үр дүнг илүү бодит байлгах зорилгоор тухайлсан дэд салбар бүрийн хувьд урьдчилсан уулзалт зохион байгуулж, тухайн

салбарын онцлогт тохирсон асуулгыг боловсруулсан билээ. Иймд дэд салбар бүрийн тухайн бизнесийн онцлогоос хамааран үйл ажиллагаан дахь нөлөө нь харилцан адилгүй байна. Харин орлого болон ажиллах хүчин, санхүү зээлийн нөхцөлтэй холбогдох нөлөө нь бүх бизнест сөргөөр нөлөөлсөн байна.

Зураг 2. Аялал жуулчлалын салбар дахь орлого, ажиллах хүчний өөрчлөлтийн матриц



Тайлбар: аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлээр ангилсан, үүнд: тур оператор: аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор; жуулчны бааз: жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудал

Орлогын нөлөө

2020-2021 онд судалгаанд оролцсон аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 98% нь цар тахлын нөлөөгөөр орлогын хэмжээ нь 2019 он ба хэвийн үетэй харьцуулахад дунджаар 76 хувиар буурсан дүнтэй байна.

Үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан харвал судалгаанд оролцсон бүх аяллын тур оператор, жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн орлогын түвшин буурсан ба хамгийн их хэмжээгээр буурсан байна.

Ажлын байрны тооны нөлөө

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчний тоондоо ямар өөрчлөлт хийсэн тухай тодруулахад дунджаар нийт ажиллагсдын 63 хувийг ба ойролцоогоор 3 ажиллагсад тутмын 2-ыг нь ажлаас чөлөөлсөн байна. Түүвэр судалгаанд оролцсон 188 компани нийт 1957 ажлын байр цомхотгосон ба аялал жуулчлалын

салбарын нэг аж ахуйн нэгж ажлын байрны тоогоо дунджаар 10-аар бууруулсан байна. Үйл ажиллагаа явуулдаг чиглэлээр нь нарийвчлан харвал аяллын тур операторын аж ахуйн нэгжүүд хамгийн ихээр ажиллах хүчний тоог бууруулсан байна. Өөрөөр хэлбэл ямар нэгэн давхар үйл ажиллагаа явуулдаггүй зөвхөн жуулчдад үйлчилдэг аяллын тур оператор, жуулчны бааз, амралтын газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд цар тахлын нөлөө хүндээр тусч орлогын хэмжээ, ажиллах хүчний тоо ихээр буурсан гэжээ.

Үйл ажиллагааны нөлөө

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн тухай тодруулахад нийт судалгаанд оролцсон жуулчны бааз (ресорт, амралтын газар, гэр буудал), зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 40% нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа бол 55% нь үйл ажиллагаагаа явуулж байна. Харин 4 аж ахуйн нэгж аялал жуулчлалын салбараас бүр мөсөн гарч, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн байна. Аялал жуулчлалын салбарын бизнест цар тахлын хамгийн гол нөлөө юу байсан тухай тодруулахад үйлчилгээний эрэлт, үйл ажиллагааны орлого буурсан, бараа материал, түүхий эдийн үнэ өссөн, зээл татвар түрээсийн өр үүссэн зэргийг нэрлэсэн байна. (Хүснэгт1)

Хүснэгт 1. Цар тахлын бизнест үзүүлсэн нөлөө

Бизнест үзүүлсэн нөлөө			
Жуулчны бааз	Тур оператор	Зочид буудал	Ресторан
- Үйлчилгээний эрэлт буурсан (77%)	- Хил хаагдаж жуулчин авч чадахгүй болсон (89%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (70.3%)	- Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (75%)
- Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (55.7%)	- Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (68.3%)	- Зээл, татвар, түрээсийн төлбөрийн өр үүссэн (51.4%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (37.5%)
- Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн, бэлэн мөнгөний хомстолд орсон (31.1%)	- Санхүүгийн эх үүсвэргүй болсон (31.7%)	- Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (51.4%)	- Зээл татвар түрээсийн төлбөрийн өр үүссэн (37.5%)

Судалгаанд оролцсон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд дунджаар бүрэн хүчин чадлынхаа 34% хувиар ажиллаж байна. Үйлчлүүлэгчийн тоо хангалттай биш, халдвар хамгааллын дэглэмтэй холбогдох УОК, засгийн газрын шийдвэр тодорхойгүй, тогтворгүй байгаа нь хүчин чадлаа бүрэн ашиглахад хүндрэл учруулж байна гэжээ. Үйл ажиллагаа явуулж байгаа салбараар нь ангилан харвал жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн 95%, зочид буудлын 78%, рестораны салбарын аж ахуйн нэгжийн 88% нь үйл ажиллагааны бүрэн хүчин чадлыг ашиглаж чадахгүй байна.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэзээ эргээд хэвийн түвшинд орох тухай хүлээлттэй байгаа тухайд 38% нь нэг жилээс дээш хугацаа шаардана гэсэн бол 28% нь нөхцөл байдал тодорхойгүй байгаа тул таамаглаж хэлж мэдэхгүй байна гэжээ. Харин 32% нь нэг жилийн дотор хэвийн түвшиндээ хүрнэ гэж таамаглаж байна.


Санхүүжилт

Жуулчны бааз, зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 79% нь үйл ажиллагаагаа сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа бол 12% нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Дээрх салбарын судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн ойролцоогоор 40%-ийг өөрийн хөрөнгөөр, 60%-ийг ямар нэгэн гадны зээл, эх үүсвэрээр санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байна. Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид ямар нэгэн санхүүгийн эх үүсвэр, хөнгөлөлттэй зээл авч чадвал эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэн салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, ажилтны цалин хөлсийг олгох гэсэн зориулалтаар зарцуулах хэрэгцээтэй байна гэжээ. Цар тахлын хүндрэлийн үед бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилготой Засгийн газрын 3 хувийн хүүтэй зээлийг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 8% нь авсан гэж хариулжээ. Цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээл хэрэгжүүлбэл зээлийн нөхцөл, шаардлагыг тухайн салбарын онцлогт тохируулах, зээлийн хугацааг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн шаардлага дээр дэмжлэг үзүүлэх гэсэн асуудлуудыг анхаарах нь зүйтэй гэж аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүд үзсэн байна.

Засгийн газрын дэмжлэг авсан байдал

Монгол улсын засгийн газраас цар тахлын хүндрэлтэй үед бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд хэрхэн хүрсэн тухайд тодруулахад давхардсан тоогоор 48.4% нь ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт, 39.4% нь НДШ-ийн хөнгөлөлт, 32.4% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтан бүрд 3 сарын хугацаанд сар бүр 200 мянган төгрөгийн бэлэн мөнгөний дэмжлэг олгох гэсэн дэмжлэгүүдийг хамгийн их хүртээмжтэй байж, хамрагдсан гэжээ.

Зураг 3. Засгийн газрын дэмжлэг авсан байдал



II. Бизнесээ сэргээхэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэг

Бизнесээ сэргээхэд тулгарч буй бэрхшээл

Аялал жуулчлалын салбарт 2022 онд бизнесээ сэргээхэд ямар хүндрэл үүсээд байгаа тухайд тодруулахад үйл ажиллагаа явуулж буй чиглэлээс хамааран ялгаатай байгаа ба ресторан, зочид буудлын салбарын хувьд түүхий эд, материалын үнийн өсөлт, хуримтлагдсан татварын өр, үл хөдлөх хөрөнгийн татвар хүндрэл учруулж байна. Жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд салбарын онцлогийг харгалзаж үзээгүй бодлого, уялдаа холбоогүй хуулийн зохицуулалтууд, үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авах ойлгомжгүй зохицуулалтууд, газрын татвар төлбөр хүндрэл үүсгэж байна. Аяллын тур оператор компанийн хувьд гадаад нислэгийн хуваарь тодорхойгүй, гадаад улсад маркетинг сурталчилгаа сэргээх болон эргэлтийн хөрөнгөтэй холбоотой төсөв хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох нь хүндрэлтэй байна гэжээ. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Бизнесээ сэргээхэд тулгарч буй хүндрэл

2022 онд жуулчин хүлээж авахад тулгарч буй хүндрэл			
Жуулчны бааз	Тур оператор	Зочид буудал	Ресторан
<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын салбарын онцлогийг харгалзаж үзээгүй бодлого, хуулийн зохицуулалтууд (50.8%) - Үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авахтай холбогдох ойлгомжгүй байдал (39.3%) - Газрын татвар, төлбөр (34.4%) 	<ul style="list-style-type: none"> - Гадаад нислэгийн хуваарь тодорхойгүй (64.6%) - Гадаад маркетинг сурталчилгаа хийх хөрөнгө төсөв (45.1%) - Эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр буюу зээл (43.9%) 	<ul style="list-style-type: none"> - Хуримтлагдсан татварын өр төлөлт (51.4%) - НДШ, ХАОАТ-ын хуримтлагдсан өр (51.4%) - Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (43.2%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (35.1) 	<ul style="list-style-type: none"> - Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (75%) - Хуримтлагдсан татварын өр төлөлт (50%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (37.5%)

Шаардагдах дэмжлэг

Бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулж, үйл ажиллагаагаа сэргээхэд шаардагдах дэмжлэгийн тухай тодруулахад аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд үйл ажиллагааны чиглэл харгалзахгүйгээр 2022 оныг дуустал хугацаанд ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх нь бизнесээ сэргээхэд чухал дэмжлэг болно гэжээ.

Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд аялал жуулчлалын салбарын гол

оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, төрийн үйлчилгээний хүнд суртлын бууруулах хэрэгтэй байна гэсэн бол аяллын тур операторуудын хувьд 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах нь дэмжлэг болно гэжээ. Түүнчлэн зочид буудал, рестораны аж ахуйн нэгжүүдийн хувьд ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг үргэлжлүүлэх, зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах нь бизнесээ төлөвлөж, үйл ажиллагаагаа сэргээхэд чухал дэмжлэг болно гэжээ. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Бизнесээ сэргээхэд шаардагдах дэмжлэг

Цаашид шаардагдах дэмжлэг			
Жуулчны бааз	Тур оператор	Зочид буудал	Ресторан
<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох (47.5%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (45.9%) - Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах (29.5%) 	<ul style="list-style-type: none"> - 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах (61.7%) - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2022 он дуустал олгох (61.7%) - НДШ-ээс хөнгөлөх, чөлөөлөх, төлөх хугацааг хойшлуулах (59.3%) 	<ul style="list-style-type: none"> - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (51.4%) - Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (45.9%) - Үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах, хөл хорио тогтоохгүй байх (37.8%) 	<ul style="list-style-type: none"> - Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (75%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (50%) - Зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (37.5%)

IV. Ерөнхий үр дүн

- Судалгаанд оролцсон аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 98% нь цар тахлын нөлөөгөөр 2020-2021 онд орлогын хэмжээ нь дунджаар 76% буурсан байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан харвал судалгаанд оролцсон бүх аяллын тур оператор, жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн орлогын түвшин буурсан ба хамгийн их хэмжээгээр буурчээ.
- Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр дунджаар нийт ажиллагсдын 63 хувийг ба ойролцоогоор 3 ажиллагсад тутмын 2-ыг нь ажлаас чөлөөлсөн байна. Үйл ажиллагаа явуулдаг чиглэлээр нь нарийвчлан харвал аяллын тур операторын аж ахуйн нэгжүүд хамгийн ихээр ажиллах хүчний тоог бууруулсан байна.
- Ямар нэгэн давхар үйл ажиллагаа явуулдаггүй зөвхөн жуулчдад үйлчилдэг аяллын тур оператор, жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын аж ахуйн нэгжүүдэд цар тахлын нөлөө илүү хүндээр тусч орлогын хэмжээ, ажиллах хүчний тоо ихээр буурсан байна.

- Үйлчилгээний эрэлт, үйл ажиллагааны орлого буурсан, бараа материал, түүхий эдийн үнэ өссөн, зээл татвар түрээсийн өр үүссэн зэрэг нь аялал жуулчлалын салбарын бизнест цар тахлын хамгийн гол нөлөө үзүүлж, үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчид бүрэн хүчин чадлынхаа 34% хувиар ажиллаж байна.
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэзээ эргээд хэвийн түвшинд орох тухай хүлээлттэй байгаа тухайд 38% нь нэг жилээс дээш хугацаа шаардана гэсэн бол 28% нь нөхцөл байдал тодорхойгүй байгаа тул таамаглаж хэлж мэдэхгүй гэжээ. Харин 32% нь нэг жилийн дотор хэвийн түвшиндээ хүрнэ гэж таамаглаж байна.
- Жуулчны бааз, зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 79% нь үйл ажиллагаагаа сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байна. Түүнчлэн санхүүгийн эх үүсвэртэй болбол юунд зарцуулах тухайд эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэн салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, ажилтны цалин хөлсийг олгох зэргийг нэрлэсэн байна.
- Цар тахлын хүндрэлийн үед бизнес эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилготой Засгийн газрын 3 хувийн хүүтэй зээлийг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 8% нь авсан ба цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээл хэрэгжүүлбэл зээлийн нөхцөл, шаардлагыг тухайн салбарын онцлогт тохируулах, зээлийн хугацааг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн шаардлага дээр дэмжлэг үзүүлэх зэргийг анхаарах нь зүйтэй гэжээ.
- Засгийн газрын дэмжлэг арга хэмжээ аялал жуулчлалын салбарт хүртээмжтэй байсан эсэхийг тодруулахад давхардсан тоогоор 48.4% нь ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт, 39.4% нь НДШ-ийн хөнгөлөлт, 32.4% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд үзүүлэх дэмжлэг гэсэн арга хэмжээнүүд хамгийн хүртээмжтэй байж, хамрагдсан гэжээ.
- Аялал жуулчлалын салбарт 2022 онд бизнесээ сэргээхэд учирч буй хүндрэлийг тодруулахад үйл ажиллагааны чиглэлээс хамааран ялгаатай байгаа ба ресторан, зочид буудлын аж ахуйн нэгжид түүхий эд, материалын үнийн өсөлт, хуримтлагдсан татварын өр, үл хөдлөх хөрөнгийн татвар хүндрэлтэй байна. Жуулчны бааз, ресорт, амралтын газар, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд салбарын онцлогийг харгалзаж үзээгүй бодлого, уялдаа холбоогүй хуулийн зохицуулалтууд, үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авах ойлгомжгүй зохицуулалтууд хүндрэл үүсгэж байна. Аяллын тур оператор компанийн хувьд гадаад нислэгийн хуваарь тодорхойгүй, гадаад улсад маркетинг сурталчилгаа сэргээх болон эргэлтийн хөрөнгөтэй холбоотой санхүүгийн эх үүсвэр олох нь хүндрэлтэй байна гэжээ.
- Бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулж, үйл ажиллагаагаа сэргээхэд шаардагдах дэмжлэгийн тухайд үйл ажиллагааны чиглэл харгалзахгүйгээр 2022 оныг дуустал хугацаанд ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх нь бизнесээ сэргээхэд чухал дэмжлэг болно гэжээ.
- Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд *аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, төрийн үйлчилгээний*

хүнд суртлын бууруулах хэрэгтэй байна гэсэн бол аяллын тур операторуудын хувьд 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах нь дэмжлэг болно гэжээ. Түүнчлэн зочид буудал, рестораны аж ахуйн нэгжүүдийн хувьд ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг үргэлжлүүлэх, зээлийн төлбөр, хүү, хугацаатай холбоотой дэмжлэг шаардлагатай байна.

**1. Цар тахлын үеийн аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдлын нэгдсэн матриц
(үйл ажиллагааны чиглэлээр)**

	Ресторан	Зочид буудал	Жуулчны бааз	Тур оператор
Үйл ажиллагаа, бизнес дэх нөлөө				
Үйл ажиллагаа явуулж байгаа эсэх	- Үйл ажиллагаа явуулж байгаа (100%)	- Үйл ажиллагаа явуулж байгаа (89.2%) - Үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа (5.4%)	- Үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа (68.9%) - Үйл ажиллагаа явуулж байгаа (27.9%)	-
Орлого, Ажлын байрны тооны өөрчлөлт	- Орлого: 51% буурсан - Ажлын байрны тоо: 50% буурсан	- Орлого: 63% буурсан - Ажлын байрны тоо: 25% Буурсан	- Орлого: 84% буурсан - Ажлын байрны тоо: 68% буурсан	- Орлого: 80% буурсан - Ажлын байрны тоо: 78% буурсан
Бизнес үзүүлсэн нөлөө	- Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (75%) - Үйлчилгээний эрэлт буурсан (37.5%) - Зээл татвар түрээсийн төлбөрийн өр үүссэн (37.5%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (70.3%) - Зээл, татвар, түрээсийн төлбөрийн өр үүссэн (51.4%) - Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (51.4%)	- Үйлчилгээний эрэлт буурсан (77%) - Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (55.7%) - Бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн, бэлэн мөнгөний хомстолд орсон (31.1%)	- Хил хаагдаж жуулчин авч чадахгүй болсон (89%) - Орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (68.3%) - Санхүүгийн эх үүсвэргүй болсон (31.7%)
Засгийн газрын дэмжлэгийн хүртээмж	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (100%) - НДШ-ийн хөнгөлөлт (87.5%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (75%)	- ЗГ-ын 3 хувийн зээл (67.6%) - НДШ-ийн хөнгөлөлт (62.2%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (40.5%)	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (45.9%) - НДШ-ийн хөнгөлөлт (37.7%) - Ямар нэг дэмжлэг аваагүй (31.1%)	- Ус цахилгаан дулааны төлбөр хөнгөлөлт, чөлөөлөлт (50%) - Ямар нэг дэмжлэг аваагүй (31.7%) - Ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/ 3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ (31.7%)

Бизнесээ сэргээхэд тулгарч буй хүндрэл, шаардагдах дэмжлэг				
2022 онд жуулчин хүлээж авахад тулгарч буй хүндрэл	<ul style="list-style-type: none"> - Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (75%) - Хуримтлагдсан татварын өр төлөлт (50%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (37.5%) 	<ul style="list-style-type: none"> - Хуримтлагдсан татварын өр төлөлт (51.4%) - НДШ, ХАОАХ-ын хуримтлагдсан өр (51.4%) - Түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (43.2%) - Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (35.1) 	<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын салбарын онцлогийг харгалзаж үзээгүй бодлого, хуулийн зохицуулалтууд (50.8%) - Үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авахтай холбогдох ойлгомжгүй байдал (39.3%) - Газрын татвар төлөлт (34.4%) 	<ul style="list-style-type: none"> - Гадаад нислэгийн хуваарь тодорхойгүй (64.6%) - Гадаад маркетинг сурталчилгаа хийх санхүүгийн эх үүсвэр (45.1%) - Эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр буюу зээл (43.9%)
Цаашид шаардагдах дэмжлэг	<ul style="list-style-type: none"> - Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (75%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (50%) - Зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (37.5%) 	<ul style="list-style-type: none"> - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (51.4%) - Ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээг хойшлуулах (45.9%) - Үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах, хөл хорио тогтоохгүй байх (37.8%) 	<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох (47.5%) - ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (45.9%) - Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах (29.5%) 	<ul style="list-style-type: none"> - 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах (61.7%) - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг 2022 он дуустал олгох (61.7%) - НДШ-ээс хөнгөлөх, чөлөөлөх, төлөх хугацааг хойшлуулах (59.3%)
Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт	<ul style="list-style-type: none"> - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (75%) - Шинэ ажлын байр бий болгох (37.5%) - Ажилтны цалин хөлсөнд зарцуулах (25%) 	<ul style="list-style-type: none"> - Ажилтны цалин хөлсөнд зарцуулах (48.6%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (45.9%) - Шинэ ажлын байр бий болгох (29.7%) 	<ul style="list-style-type: none"> - Эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх (52.5%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (52.5%) - Шинэ ажлын байр бий болгох (34.4%) 	<ul style="list-style-type: none"> - Гадаад зах зээлд сурталчилгаа шинээр хийх (47.6%) - Ажлын байрыг өргөтгөж, нэмэх (39%) - Салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (22%)

V. Дэд салбаруудаарх дэлгэрэнгүй тайлан

2. Аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор

Аялал жуулчлалын салбарын нэг гол дэд салбар нь аялал жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд юм. Аялал жуулчлалын зөвлөлийн статистик мэдээгээр энэ салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 571 аж ахуйн нэгж байгаа ба энэхүү түүвэр судалгаанд 82 аж ахуйн нэгж оролцсон болно. Аялал жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн онцлог нь ихэвчлэн жуулчдад чиглэн гол үйл ажиллагаа явуулдаг бөгөөд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь энэ чиглэлийн бизнес эрхлэгчдэд хамгийн ихээр сөргөөр нөлөөлсөн байна. Энэхүү судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 91% нь нэг тэрбум хүртэлх төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүд байгаа ба 52.4% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан харьцангуй тогтворжсон аж ахуй нэгжүүд хамрагджээ.

Гол үр дүн:


- Аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор (тур оператор)-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд хил хаагдаж жуулчин авч чадахгүй болсон (89%), орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон (68.3%), санхүүгийн эх үүсвэргүй болсон (31.7%), ажилчдаа цомхтгосон буюу ажиллах хүнгүй болсон (30.5%) зэргээр бизнесийн үйл ажиллагаанд нь цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нөлөөлсөн байна. Мөн шинээр эхлэхээр бэлтгэж төлөвлөсөн зах зээлийн боломжоо алдсан (40.2%), аяллын машин техник хэрэгслээ зарж борлуулж цөөлсөн (55%), түрээсийн байрнаасаа гарч гэрээсээ ажилладаг болсон (48%) зэргээр аж ахуйн нэгжүүдийн зах зээлийн боломж, үйл ажиллагааны үндсэн нөөцөд нөлөөлсөн байна.
- 2020-2021 онд хэвийн түвшинтэй харьцуулахад судалгаанд оролцсон тур операторын бизнес эрхлэгчдийн орлогын хэмжээ нь цар тахлын нөлөөгөөр 80%-иар буурсан бол ажлын байрны тоог 78%-иар ба 767 ажлын байрыг цомхотгоод байна.
- Судалгаанд оролцсон тур операторын аж ахуйн нэгжүүдийн 58% нь бизнесийн зээлтэй байгаа ба зээлтэй аж ахуйн нэгжийн 39% нь зээлийн хүсэлт гарган зээл төлөх хугацааг хойшлуулсан, 39% нь зээлийн төлөлтөд доголдол үүссэн бол 20% нь найдваргүй зээлдэгч болжээ.
- Засгийн газрын бизнесийг дэмжих арга хэмжээнүүдээс ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх, чөлөөлөх (50%), ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх (31.7%), НДШ-ийн хөнгөлөлт (25.6%) зэрэг нь тур операторын аж ахуйн нэгжүүдэд илүү хүртээмжтэй байсан бол 31.7% нь ямар нэг дэмжлэгт хамрагдаж чадаагүй байна.

Бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тур операторын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдэд 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах (61.7%), татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг 2022 он дуустал сунгах (61.7%), НДШ-ээс чөлөөлөх, хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах (59.3%) зэрэг арга хэмжээ дэмжлэг болно гэжээ.

Үйл ажиллагаан дах нөлөө


Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор (тур оператор)-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлсөн тухайд тодруулахад давхардсан тоогоор 89% нь хил хаагдаж жуулчин авч чадахгүй болсон, 68.3% нь орлого ихээр буурсан буюу орлогогүй болсон, 31.7% нь санхүүгийн эх үүсвэргүй болсон, 30.5% нь ажилчдаа цомхотгосон буюу ажлаас халж ажиллах хүнгүй болсон зэрэг нөлөөллийг нэрлэсэн байна. (Зураг 1)

Зураг 1. Ковид-19-ээс сэргийлэх, хөл хорионы хязгаарлалтын арга хэмжээний бизнест үзүүлсэн нөлөө




Судалгаанд оролцсон тур операторын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулдаг үндсэн нөөцүүд цар тахлын нөлөөллөөр хэрхэн өөрчлөгдсөн тухай тодруулахад давхардсан тоогоор 55% нь аяллын машин техник хэрэгслээ зарж борлуулж цөөлсөн, 48% нь түрээсийн байрнаасаа гарч гэрээсээ ажилладаг болсон, 26% нь аяллын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалтын хугацаа дуусаж ашиглах боломжгүй болсон зэргийн дурджээ. (Зураг 2)

Зураг 2. Цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагааны үндсэн нөөцүүдийн өөрчлөлт



Аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр зах зээлээс ямар алдагдал, хохирол хүлээсэн тухайд 81.7% нь жуулчин хүлээн авахтай холбогдох үйл ажиллагааны гол орлогоо алдсан, 40.2% нь шинээр эхлэхээр бэлтгэж төлөвлөсөн зах зээлийн боломжоо алдсан бол 36.6% нь компани өсөн дэвжиж нэр хүнд, ашиг орлого нэмэгдүүлэх боломжоо алдсан гэжээ. (Зураг 3)


Зураг 3. Цар тахлын нөлөөгөөр зах зээлээс алдагдсан боломжууд



Орлогын нөлөө

Цар тахлын нөлөөгөөр хэвийн түвшин ба 2019 онтой харьцуулахад 2020-2021 онд судалгаанд оролцсон тур операторын бүх аж ахуйн нэгжүүдийн орлого буурсан. Орлогын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн тухайд тодруулахад аж ахуйн нэгжүүдийн 54.9% нь орлогоо 100% алдсан бөгөөд тур операторын аж ахуйн нэгжүүдийн хувьд орлогын хэмжээ нь дунджаар 80%-иар буурсан байна. (Зураг 4)

Зураг 4. Орлогын хэмжээнд нөлөөлсөн байдал



Ажлын байрны нөлөө

Судалгаанд оролцсон тур операторын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчиндээ хэрхэн өөрчлөлт оруулсан тухай тодруулахад 90% нь ямар нэгэн байдлаар ажлын байрны тоог бууруулсан бол давхардсан тоогоор 6% нь цаашид ажлын байрны тоог бууруулна гэсэн бол 11% нь ажлын байрны тоог цөөлөхгүйгээр ажиллагсдаа авч үлдэхээр хичээж байна гэжээ.

Ажлын байрны тоог хэрхэн бууруулсан тухайд 13% нь 50-80% хүртэлх ажлын байрны тоог бууруулсан бол 41% нь ажлын байрны тоогоо 81-90% бууруулсан, 35% нь бүх ажилчдаа халсан ба дунджаар нийт судалгаанд оролцсон тур операторуудын хувьд ажлын байрны тоог **78%-иар** ба нийт **767** ажлын байрыг цомхотгоод байна гэжээ. (Зураг 5)


Зураг 5. Цар тахлаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын байрны тоонд орсон



Санхүүжилт

Судалгаанд оролцсон тур операторын аж ахуйн нэгжүүдийн 58% нь бизнесийн зээлтэй байна. Зээлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд 39% нь зээлийн хүсэлт гарган зээл төлөх хугацааг хойшлуулсан, 39% нь зээлийн төлөлтөд доголдол үүссэн, 20% нь найдваргүй зээлдэгч болсон бол 10% нь зээлээ төлж байгаа гэжээ. (Зураг 6)

Зураг 6. Зээл төлөлттэй холбогдох хүндрэлүүд



Тур операторын аж ахуйн нэгжүүд хэрэгцээт санхүүжилт авбал юунд зарцуулах тухайд тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдийн 47.6% нь гадаад зах зээлд сурталчилгаа шинээр хийх, 39% нь ажлын байрыг өргөтгөж нэмэх, 22% нь салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, 19.5% нь эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зэрэгт зарцуулна гэсэн байна. (Зураг 7)

Зураг 7. Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт



Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл, шаардлагатай дэмжлэгүүд

Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл

Бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад тур операторын бизнест үүсээд буй хүндрэл, шаардагдах дэмжлэгийг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 64.6% нь гадаад нислэгийн хуваарийг тодорхой болгох, 45.1% нь гадаад маркетинг сурталчилгаа хийх санхүүжилт олох, 43.9% эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр буюу зээлийн эх үүсвэр зэргийг хамгийн гол хүндрэл үүсгээд байна гэжээ. (Зураг 8)

Зураг 8. Бизнесээ сэргээж, жуулчин хүлээж авахад тулгарч буй хүндрэл, шаардагдах дэмжлэг



Засгийн газрын дэмжлэгт хамрагдсан байдал болон цаашид шаардагдах дэмжлэг

Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг авсан тухайд судалгаанд оролцогсдын 50% нь ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх, чөлөөлөх, 31.7% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/, 25.6% нь НДШ-ийн хөнгөлөлтөд хамрагдсан гэжээ. Харин 31.7% нь аль нэг дэмжлэгт хамрагдаж чадаагүй байна. (Зураг 9)

Зураг 9. Засгийн газраас авсан дэмжлэг



Бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад нийт судалгаанд оролцсон тур операторын бизнес эрхлэгчдийн давхардсан тоогоор 61.7% 2022 оны гадаад, дотоод нислэгийн хуваарийг яаралтай баталж зарлах, мөн 61.7% нь татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг 2022 он дуустал сунгах, 59.3% нь НДШ-ээс чөлөөлөх, хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэжээ. (Зураг 14)

Зураг 14. Цаашид бизнесээ сэргээхэд төрөөс шаардлагатай дэмжлэг, арга хэмжээнүүд



Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудал

Аялал жуулчлалын салбарын зочилох үйлчилгээний дэд салбарт харьяалагддаг, нэг гол бизнесийн чиглэл нь жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд юм. Аялал жуулчлалын салбарын статистик мэдээгээр энэ салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 448 аж ахуйн нэгж байгаа ба энэхүү түүвэр судалгаанд 61 аж ахуйн нэгж оролцсон болно. Энэхүү судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 78.7% нь 300 сая төгрөг хүртэлх орлоготой аж ахуйн нэгжүүд байгаа ба 62.3% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан харьцангуй тогтворжсон аж ахуй нэгжүүд хамрагджээ.

Гол үр дүн:

- Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь үйлчилгээний эрэлт буурсан (77%), орлого ихээр буурсан ба орлогогүй болсон (55.7%), бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн болон бэлэн мөнгөний хомстолд орсон зэргээр жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд нөлөөлсөн байна. Мөн судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 27.9% нь үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрийн дөнгөж 18% нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.
- 2020-2021 онд хэвийн түвшинтэй харьцуулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн орлогын хэмжээ нь цар тахлын нөлөөгөөр 84%-иар буурсан бол ажлын байрны тоог 68%-иар ба 593 ажлын байрыг цомхотгоод байна.
- Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд хөнгөлөлттэй зээл олгох (62.3%), ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг (52.5%), НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах (42.6%) зэрэг дэмжлэгүүд хэрэгтэй байна.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 90.2% нь бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа ба шаардлагатай санхүүжилтээ салбартаа үйл ажиллагаа өргөжүүлэх (52.5%), шинэ ажлын байр бий болгох (34.4%), зээлийн хүүгээ төлөх (31.1%) зэрэгт зарцуулна гэжээ.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээ (45.9%), НДШ-ийн хөнгөлөлт (37.7%), ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх /3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ зэрэг засгийн газрын дэмжлэгийг авсан байна. Харин эдгээр бизнес эрхлэгчдийн хувьд засгийн газрын 3 хувийн зээлд барьцаа хөрөнгийн асуудлаас болж хамрагдаж чадаагүй байна.
- Бизнесээ тасралтгүй явуулахад аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд тухайн салбарын онцлогийг харгалзан үзээгүй бодлого, хуулийн зохицуулалтууд (50.8%), үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авахтай холбогдох ойлгомжгүй байдал (39.3%), эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр (36.1%), газрын татвар, төлбөрийн

төлөлт, бусад НДШ, ХАОАТ-ын хуримтлагдсан өр зэрэг асуудлууд хамгийн гол хүндрэл үүсгээд байна гэжээ.

- Цаашид бизнесээ сэргээхэд аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох (47.5%), ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (45.9%), төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах (29.5%) зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Бизнес эрхлэгчдийн 24.6% нь нэг жилийн дотор бизнесийн үйл ажиллагаа буцаад хэвийн түвшиндээ хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Үйл ажиллагаан дах нөлөө

Судалгаанд оролцсон жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 27.9% нь үйл ажиллагаа явуулж байгаа, 68.9% нь үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа, 1.6% нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн гэсэн бол үлдсэн хэсэг нь зах зээлээс бүр мөсөн гарсан гэж хариулжээ. Мөн эдгээр аж ахуйн нэгжийн дөнгөж 18% нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Үйлчлүүлэгчдийн тоо хангалттай биш, УОК, Засгийн газрын шийдвэрүүд тодорхойгүй байгаа учир бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлсөн тухайд тодруулахад давхардсан тоогоор 77% нь үйлчилгээний эрэлт буурсан, 55.7% нь орлого ихээр буурсан ба орлогогүй болсон, бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн болон бэлэн мөнгөний хомстолд орсон зэрэг нөлөөллийг нэрлэсэн байна. (Зураг 1)


Зураг 1. Ковид-19-ээс сэргийлэх, хөл хорионы хязгаарлалтын арга хэмжээний бизнест үзүүлсэн нөлөө



Аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр зах зээлээс ямар алдагдал, хохирол хүлээсэн тухайд 82% нь жуулчин хүлээн авахтай холбогдох үйл ажиллагааны гол

орлогоо алдсан, 47.5% нь шинээр эхлэхээр бэлтгэж төлөвлөсөн зах зээлийн боломжоо алдсан бол 44.3% нь компани өсөн дэвшиж нэр хүнд, ашиг орлого нэмэгдүүлэх боломжоо алдсан гэжээ. (Зураг 2)

Зураг 2. Цар тахлын нөлөөгөөр зах зээлээс алдагдсан боломжууд



Орлогын нөлөө

Цар тахлын нөлөөгөөр хэвийн түвшин ба 2019 онтой харьцуулахад 2020 онд судалгаанд оролцсон жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 96.7% нь орлого буурсан гэсэн бол 2021 онд аж ахуйн нэгжүүдийн 95.2% нь орлого буурсан гэсэн байна. Орлогын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн тухайд тодруулахад хэвийн түвшинтэй (2019 онтой) харьцуулахад 2020 онд 83%-иар буурсан бол 2021 онд 85.7%-иар буурч, 2020-2021 онд цар тахлын нөлөөгөөр орлогын хэмжээ дунджаар 84%-иар буурсан байна. (Зураг 2).

Зураг 2. Орлогын буурсан хэмжээ (2020-2021 он)




Ажлын байрны нөлөө

Судалгаанд оролцсон жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр ажлын байрандаа хэрхэн өөрчлөлт оруулсан тухай тодруулахад 91.8% нь ямар нэгэн байдлаар ажлын байрны тоог бууруулсан бол давхардсан тоогоор 4.9% нь өөрчлөлт оруулаагүй, 6.6% нь цаашид ажлын бууруулна гэжээ.

Ажлын байрны тоог хэрхэн бууруулсан тухайд 6.6% нь 30% хүртэлх ажлын байрны тоог бууруулсан бол 26.2% нь ажлын байрны тоогоо 31-80% бууруулсан,

59% нь 80%-аас дээш хэмжээгээр болон бүх ажилчдаа халсан ба дунджаар нийт судалгаанд оролцсон 61 аж ахуйн нэгж ажлын байрны тоогоо **68%-иар** ба **593** ажлын байрыг цомхотгоод байна гэжээ. (Зураг 3)

Зураг 3. Цар тахлаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын байрны тоонд орсон өөрчлөлт




Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч байгаа бэрхшээлийг тодруулахад давхардсан тоогоор 67% нь үйл ажиллагаа зогссон доголдсон, 46% орлого буурсан, 31% нийт үйл ажиллагааны зардлаа бууруулах шаардлагатай болсон, 44% нь үнийн өсөлтийн нөлөөгөөр цалин нэмэх, цар тахлаас шалтгаалан хамгаалах хэрэгслээр хангах зэргээр ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн гэжээ. (Зураг 4)

Зураг 4. Ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч буй бэрхшээлүүд



Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд шаардлагатай дэмжлэгүүдийг тодруулахад 62.3% хөнгөлөлттэй зээл олгох, 52.5% нь ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг, 42.6% нь НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах зэрэг дэмжлэгүүд хэрэгтэй гэсэн байна (Зураг 5). Ажлын байраа хадгалахад шаардагдах дэмжлэгийг аж ахуйн нэгжийн ажиллагсдын тооны бүлгээр ангилан авч үзвэл бүлгийн ялгаагүйгээр НДШ, ХАОАТ-ийн төлбөрийг хойшлуулах болон төрөөс ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл хэрэгтэй гэж үзсэн байна.


Зураг 5. Ажлын байраа хадгалж үлдэхэд төрөөс шаардлагатай дэмжлэгүүд



Санхүүжилт

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 75.4% нь зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд 17.4% нь зээлийн хүсэлт гарган зээл төлөх хугацааг хойшлуулсан, 32.6% нь зээлийн төлөлтөд доголдол үүссэн, 28.3% нь найдваргүй зээлдэгч болсон бол 21.7% нь зээлээ төлж байгаа гэжээ. Аж ахуйн нэгжүүдийн 90.2% бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа бол 8.2% нь нөхцөл байдал тодорхойгүй байгаа учир хэлж мэдэхгүй байна, 1.6% нь одоохондоо зээл авах хэрэгцээ байхгүй гэжээ. Зээл, санхүүжилт хэрэгцээтэй байгаа аж ахуйн нэгжүүдээс цаашид ямар эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 18% нь өөрийн эргэлтийн хөрөнгөөр, 27.9% нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг нэрлэсэн бол 34.4% нь ямар нэг эх үүсвэр байхгүй гэжээ. (Зураг 7)

Зураг 7. Үйл ажиллагааг сэргээхэд санхүүжүүлж байгаа (эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй) эх үүсвэрүүд



Цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөр хэрэгжүүлбэл давхардсан тоогоор 80.3% нь зээлийн нөхцөл, шаардлагыг тухайн салбарын онцлогт тохируулах, 75,4% нь барьцаа хөрөнгийн шаардлага дээр дэмжлэг үзүүлэх, 70.5% нь зээлийн хугацааг нэмэгдүүлэх, 57.4% нь зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, 16.4% нь зээлийн дэлгэрэнгүй, тодорхой мэдээллийг түгээх тал дээр анхаарах шаардлагатай гэж үзжээ. (Зураг 8)

Зураг 8. Эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөрт анхаарах шаардлагатай асуудлууд



Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын бизнес эрхлэгчдээс шаардлагатай санхүүжилтээ авч чадвал ямар зориулалтаар зарцуулах тухай тодруулахад 52.5% нь эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, 34.4% нь шинэ ажлын байр бий болгох, 31.1% нь зээлийн хүүгээ төлөх, 29.5% гадаад зах зээлд маркетинг, сурталчилгаа шинээр хийх зэрэгт зарцуулна гэжээ. (Зураг 9)


Зураг 9. Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт



Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх тухай хүлээлт

Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын бизнес эрхлэгчдээс хэзээ үйл ажиллагаа хэвийн ба 2019 онтой ижил түвшинд хүрэх тухай хүлээлттэй байгааг тодруулахад 24.6% нь ойрын нэг жилийн дотор, 42.6% нь нэг жилээс дээш хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн түвшинд хүрнэ гэж таамаглаж байгаа бол 32.8% нь нөхцөл байдал тодорхойгүй учир хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 10)

Зураг 10. Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх хүлээлтийн хугацаа




Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл, шаардлагатай дэмжлэгүүд

Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл

Жуулчны бааз, амралтын газар, ресорт, гэр буудлын бизнес эрхлэгчид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад үүсээд буй хүндрэлийг тодруулахад 50.8% нь аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд тухайн салбарын онцлогийг харгалзан үзээгүй бодлого, хуулийн зохицуулалтууд, 39.3% нь үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох үнэлгээ, зөвшөөрлийг сунгах, авахтай холбогдох ойлгомжгүй байдал, 36.1% нь эргэлтийн хөрөнгийн эх үүсвэргүй байдал, 34.1% нь газрын татвар, төлбөрийн төлөлт, НДШ, ХАОАТ-ын хуримтлагдсан өр зэрэг асуудлууд хамгийн гол хүндрэл үүсгээд байна гэжээ. (Зураг 11) Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэлийг групп ярилцлагаар дэлгэрүүлэн асуухад 1)газрын төлбөр, татварын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалт байхгүй, тухайн орон нутаг өөрсдөө төлбөрийн хэмжээг баталдаг учир зарим бүсд хэтэрхий өндөр байдаг ба 2020-2021 онуудад орлого ихээр буурсан боловч газрын төлбөрийн өр үүссэн 2) аж ахуйн нэгжийн газар эзэмших тусгай зөвшөөрөл олгох үйл явц хүндрэлтэй, 3)ойн сан, усны сантай холбогдох тусгай зөвшөөрөл олголтын ойлгомжгүй байдал, зөвшөөрлийн хугацаа хэт богино, 4)төрийн байгууллага хоорондын уялдаа холбоогүй байдал зэрэг нь ихээхэн хүндрэл үүсгэж байгаа тухай онцолсон юм.

Зураг 11. Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэлүүд



Засгийн газрын дэмжлэгт хамрагдсан байдал болон цаашид шаардагдах дэмжлэгүүд

Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг авсан тухайд 45.9% нь ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх чөлөөлөлт, 37.7% НДШ-ийн хөнгөлөлт, 23% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх/3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ зэрэгт хамрагдсан гэжээ (Зураг 12)

Зураг 12. Засгийн газраас авсан дэмжлэгүүд



Цаашид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 47.5% нь аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, 45.9% нь ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх, 29.5% нь төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах, 27.9% нь газрын төлбөрийг хөнгөлөх, хойшлуулах, 26.2% нь зээлийн төлбөр хүү төлөх хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэжээ (Зураг 13)

Зураг 13. Цаашид бизнесээ сэргээхэд төрөөс шаардлагатай дэмжлэг, арга хэмжээнүүд



Зочид буудал

Аялал жуулчлалын салбарын зочлох дэд салбарт үйл ажиллагаа явуулдаг нэг гол бизнесийн чиглэл нь зочид буудал юм. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 498 зочид буудал үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү судалгаанд жуулчдад голлон үйлчилдэг 37 зочид буудал оролцсон болно. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 48.6% нь 300 сая хүртэлх, 35.1% нь 301 саяас 2.5 тэрбум төгрөгийн, 16.2% нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой байна. Мөн эдгээр аж ахуйн нэгжүүдийн 43.2% нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа ба одоогоор 89.2% нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

Гол үр дүн:

- Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь үйлчилгээний эрэлт буурсан (70.3%), зээл, татвар, түрээсийн төлбөрийн өр үүссэн (51.4%), бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (51.4%), хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхойгүй байдал үүссэн (24.3%) зэргээр зочид буудлын бизнес эрхлэгчдэд нөлөөлж судалгаанд оролцсон зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 37 аж ахуйн нэгжийн дөнгөж 21.6% нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.
- 2020-2021 онд хэвийн түвшинтэй харьцуулахад судалгаанд оролцсон зочид буудлын бизнес эрхлэгчдийн орлогын хэмжээ нь цар тахлын нөлөөгөөр 62.8%-иар буурсан бол ажлын байрны тоог 25%-иар ба 304 ажлын байрыг цомхотгоод байна.
- Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах (70.3%), ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг (32.4%), төрийн халамжийн бодлогыг бизнесийн ажил эрхлэлттэй уялдуулах (32.4%) зэрэг дэмжлэгүүд хэрэгтэй байна гэжээ.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 64.9% нь бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа ба шаардлагатай санхүүжилтээ ажилтны цалин хөлсөнд зарцуулах (48.6%), салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх (45.9%), шинэ ажлын байр бий болгох (29.7%) зэрэгт зарцуулна гэжээ.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 67.6% нь Засгийн газрын 3 хувийн зээлд хамрагдсан бол 62.2% НДШ-ийн хөнгөлөлт, 40.5% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх /3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ арга хэмжээнд хамрагдсан зэргээр засгийн газрын бизнесийг дэмжих үйл ажиллагаа зочид буудлын бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй байсан байна.
- Бизнесээ тасралтгүй явуулахад хуримтлагдсан татварын өр төлөлт (51.4%), НДШ, ХАОАТ-ын хуримтлагдсан өр (51.4%), түүхий эд, бараа материалын үнэ (43.2%), үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (35.1%) зэрэг асуудлууд хүндрэл үүсгээд байна.
- Цаашид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай байгаа дэмжлэгүүдийг тодруулахад ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (51.4%), Засгийн газраас ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээний хэрэгжих хугацааг 2022 он дуустал сунгах (45.9%), аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох (37.8%) зэрэг арга хэмжээг бодит дэмжлэг болно гэжээ.
- Зочид буудлын бизнес эрхлэгчдийн 35.1% нь нэг жилийн дотор бизнесийн үйл ажиллагаа буцаад хэвийн түвшиндээ хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Үйл ажиллагаан дах нөлөө

Судалгаанд оролцсон жуулчдад гэрээгээр голлон үйлчилдэг зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 37 аж ахуйн нэгжүүдийн 89.2% нь үйл ажиллагаа явуулж байгаа, 5.4% нь үйл ажиллагаа түр зогссон, дахин эхлэхээр төлөвлөж байгаа гэсэн бол үлдсэн хэсэг нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн байна. Мөн эдгээр аж ахуйн нэгжийн дөнгөж 21.6% нь бүрэн хүчин

чадлаараа ажиллаж байна. Үйлчлүүлэгчдийн тоо хангалттай биш, УОК, Засгийн газрын шийдвэрүүд тодорхойгүй, хүний нөөцийн хомсдол үүссэн зэрэг шалтгаанаар зочид буудлууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлсөн тухайд тодруулахад давхардсан тоогоор 70.3% нь үйлчилгээний эрэлт буурсан, 51.4% нь зээл, татвар, түрээсийн төлбөрийн өр үүссэн болон бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн зэрэг нөлөөллийг нэрлэсэн байна. (Зураг 1)


Зураг 1. Ковид-19-ээс сэргийлэх, хөл хорионы хязгаарлалтын арга хэмжээний бизнест үзүүлсэн нөлөө



Орлогын нөлөө

Цар тахлын нөлөөгөөр хэвийн түвшин ба 2019 онтой харьцуулахад 2020 онд судалгаанд оролцсон зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн 94.6% нь орлого буурсан бол 2021 онд 91.9% нь орлого буурсан гэсэн байна. Орлогын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн тухайд тодруулахад хэвийн түвшинтэй (2019 онтой) харьцуулахад 2020 онд 64.5%-иар буурсан бол 2021 онд 61.1%-иар буурч, 2020-2021 онд цар тахлын нөлөөгөөр орлогын хэмжээ дунджаар 62.8%-иар буурсан байна. (Зураг 2).

Зураг 2. Орлогын буурсан хэмжээ (2020-2021 он)




Ажлын байрны нөлөө

Судалгаанд оролцсон зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчиндээ хэрхэн өөрчлөлт оруулсан тухай тодруулахад 35.1% нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй бол давхардсан тоогоор 24.3% нь ажлын цагийг бууруулсан, 2.7% нь цаашид ажлын байрны тоог бууруулна гэжээ.


Ажлын байрны тоог хэрхэн бууруулсан тухайд 16.2% нь 30% хүртэлх ажлын байрны тоог бууруулсан бол 27.0% нь ажлын байрны тоогоо 31-80% бууруулсан, 10.8% нь 80%-аас дээш хэмжээгээр бууруулсан ба дунджаар нийт судалгаанд оролцсон 37 зочид буудлын хувьд ажлын байрны тоог **25%-иар** ба **304** ажлын байрыг цомхотгоод байна гэжээ. (Зураг 3)

Зураг 3. Цар тахлаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын байрны тоонд орсон өөрчлөлт



Зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч буй бэрхшээлийг тодруулахад давхардсан тоогоор 59.5% нийт үйл ажиллагааны зардлаа бууруулах шаардлагатай болсон, 78.4% нь үнийн өсөлтөөс шалтгаалан цалин нэмэгдүүлэх шаардлагатай болсон, цар тахлаас шалтгаалан хамгаалах хэрэгслээр хангах зэргээр ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн гэжээ. (Зураг 4)

Зураг 4. Ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч буй бэрхшээлүүд




Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд шаардлагатай дэмжлэгүүдийг тодруулахад 70.3% нь НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах, 32.4% нь ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон төрийн халамжийн бодлогыг бизнесийн салбаруудын ажил эрхлэхтэй уялдуулах зэргийг анхаарах хэрэгтэй гэсэн байна. (Зураг 5)

Зураг 5. Ажлын байраа хадгалж үлдэхэд төрөөс шаардлагатай дэмжлэгүүд



Ажлын байраа хадгалахад шаардагдах дэмжлэгийг аж ахуйн нэгжийн ажиллагсдын тооны бүлгээр ангилан авч үзвэл бүлгийн ялгаагүйгээр *НДШ, ХАОАТ-ийн төлбөрийг хойшлуулах болон төрөөс ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг* хэрэгтэй гэж үзсэн байна. Мөн бусад дэмжлэгийн хувьд 51-200 ажилтантай ААН-үүдийн хувьд төрийн халамжийн бодлогыг бизнесийн салбаруудын ажил эрхлэлттэй уялдуулах нь чухал бол 11-50 ажилтантай аж ахуй нэгжүүдийн хувьд хөнгөлөлттэй зээл олгох нь чухал байна. (Зураг 6)

Зураг 6. Ажлын байр хадгалж үлдэхэд шаардлагатай дэмжлэгүүд, ажилчдын тооны бүлгээр




Санхүүжилт

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 64.9% нь бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа бол 18.9% нь нөхцөл байдал тодорхойгүй байгаа учир хэлж мэдэхгүй байна, 16.2% нь одоохондоо зээл авах хэрэгцээ байхгүй гэжээ.

Зээл, санхүүжилт хэрэгцээтэй байгаа аж ахуйн нэгжүүдээс цаашид ямар эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 24.3% нь өөрийн хөрөнгөөр, 24.3% нь банкны бизнесийн зээл, 27% нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг нэрлэсэн байна. (Зураг 7)

Зураг 7. Үйл ажиллагааг сэргээхэд санхүүжүүлж байгаа (эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй) эх үүсвэрүүд



Цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөр хэрэгжүүлбэл давхардсан тоогоор 86.5% нь зээлийн нөхцөл, шаардлагыг тухайн салбарын онцлогт тохируулах, 73% нь зээлийн хугацааг нэмэгдүүлэх, 51.4% нь зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх зэргийг онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзжээ. (Зураг 8)

Зураг 8. Эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөрт анхаарах шаардлагатай асуудлууд



Зочид буудлын бизнес эрхлэгчдээс шаардлагатай санхүүжилтээ авч чадвал, 45.9% нь салбартаа үйл ажиллагаагаа өргөжүүлэх, 29.7% нь шинэ ажлын байр бий болгох болон ажилчдаа сургах зэрэгт зарцуулна гэжээ. (Зураг 9)


Зураг 9. Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт



Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх тухай хүлээлт

Зочид буудлын бизнес эрхлэгчдээс хэзээ үйл ажиллагаа хэвийн ба 2019 онтой ижил түвшинд хүрэх тухай хүлээлттэй байгааг тодруулахад 35.1% нь ирэх нэг жилийн дотор хугацаанд гэсэн бол 35.1% нь нэг жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрнэ гэж таамаглаж байна. Харин 24.3% хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 9)

Зураг 10. Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх хүлээлтийн хугацаа



Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл, шаардлагатай дэмжлэгүүд

Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл

Бизнесээ тасралтгүй явуулахад зочид буудлын бизнест үүсээд буй хүндрэлийг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 51.4% хуримтлагдсан татварын өр төлөлт, мөн 51.4% нь НДШ, ХАОАТ-ын хуримтлагдсан өр, 43.2% түүхий эд, бараа материалын үнэ, 35.1% нь үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт зэрэг асуудлууд хамгийн гол хүндрэлийг үүсгээд байна гэжээ (Зураг 11). Түүнчлэн групп ярилцлагаар цар тахлын нөлөөгөөр үл хөдлөх хөрөнгийн татвар болон газрын татварыг хойшлуулах, хөнгөлөх чиглэлд дэмжлэг хэрэгтэй байгаа ба үйл ажиллагаагаа бүрэн явуулж чадахгүй, орлого ихээр буурсан үед үл хөдлөх хөрөнгө болон газрын татварууд зардлын ихээхэн дарамт үүсгэж байна гэжээ.

Зураг 11. Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэлүүд



Засгийн газрын дэмжлэгт хамрагдсан байдал болон цаашид шаардагдах дэмжлэгүүд

Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг авсан тухайд судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 67.6% нь Засгийн газрын 3 хувийн зээлд хамрагдсан бол 62.2% НДШ-ийн хөнгөлөлт, 40.5% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд

дэмжлэг үзүүлэх /3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ зэрэгт хамрагдсан гэжээ. (Зураг 12)

Зураг 12. Засгийн газраас авсан дэмжлэгүүд



Цаашид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад нийт судалгаанд оролцсон зочид буудлын бизнес эрхлэгчдийн 51.4% ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх, 45.9% засгийн газраас ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээний хэрэгжих хугацааг 2022 он дуустал сунгах гэсэн бол 37.8% нь аялал жуулчлалын салбарын гол оролцогч талуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгох болон цаашид төрөөс компаниуд үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэжээ. (Зураг 13)

Зураг 13 . Цаашид бизнесээ сэргээхэд төрөөс шаардлагатай дэмжлэг, арга хэмжээнүүд



Ресторан

Аялал жуулчлалын салбарын зочлох дэд салбарт харьяалагддаг, эдийн засгийн нийтийн хоолны салбарт үйл ажиллагаа явуулдаг нэг гол бизнесийн чиглэл нь ресторан юм. Жуулчдад гэрээгээр голлон үйлчилдэг 25 орчим ресторан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү судалгаанд эдгээр ресторануудаас 8 ресторан оролцсон болно. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 4 нь 301 сая-2.5 тэрбум төгрөгийн орлоготой, нэг аж ахуйн нэгж нь 2.5 тэрбумаас дээш орлоготой байна. Мөн эдгээр аж ахуйн нэгжүүдийн 7 нь 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа ба одоогоор бүгд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

Гол үр дүн:

- Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн (75%), үйлчилгээний эрэлт буурсан (37.5% нь), зээл татвар түрээсийн төлбөрийн өр үүссэн (37.5%), хүний нөөцийн хомсдолд орсон(37.5%) зэргээр рестораны бизнес эрхлэгчдэд нөлөөлж судалгаанд оролцсон рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн нэгжийн дөнгөж 1 нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна.
- 2020-2021 онд хэвийн түвшинтэй харьцуулахад судалгаанд оролцсон рестораны бизнес эрхлэгчдийн орлогын хэмжээ нь цар тахлын нөлөөгөөр 50.6%-иар буурсан бол ажлын байрны тоог 51%-иар ба 293 ажлын байрыг цомхотгоод байна.
- Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг (75%), НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах (50%), төрийн халамжийн бодлогыг бизнесийн ажил эрхлэлттэй уялдуулах (25%) зэрэг дэмжлэгүүд хэрэгтэй байна гэжээ.
- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 62.5% нь бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа ба шаардлагатай санхүүжилтээ салбартаа үйл ажиллагаа өргөжүүлэх (75%), шинэ ажлын байр бий болгох (37.5%), ажилтны цалин хөлс болон зээлийн хүүгээ төлөх (25%) зэрэгт зарцуулна гэжээ.
- Судалгаанд оролцсон бүх аж ахуйн нэгжүүд Засгийн газрын ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээнд хамрагдсан бол, 87.5% нь НДШ-ийн хөнгөлөлт, 75% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх /3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/ арга хэмжээнд хамрагдсан зэргээр засгийн газрын бизнесийг дэмжих үйл ажиллагаа рестораны бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй байсан байна.
- Бизнесээ тасралтгүй явуулахад түүхий эд, бараа материалын үнийн өсөлт (75%), хуримтлагдсан татварын өр төлөлт (50%), үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт (35.7%) зэрэг асуудлууд хүндрэл үүсгээд байна.
- Цаашид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай байгаа дэмжлэгүүдийг тодруулахад ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээний хэрэгжих хугацааг 2022 он дуустал сунгах (75%), ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх (50%), зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах (37.5%), бизнесийг сэргээж хэвийн явуулахад төр нэгдсэн зохицуулалт хийх,

төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах(25%) зэрэг арга хэмжээг бодит дэмжлэг болно гэжээ.

- Рестораны бизнес эрхлэгчдийн 75% нь нэг жилийн дотор бизнесийн үйл ажиллагаа буцаад хэвийн түвшиндээ хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Үйл ажиллагаан дах нөлөө

Судалгаанд оролцсон жуулчдад гэрээгээр голлон үйлчилдэг рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн нэгжүүд бүгд үйл ажиллагаа явуулж байгаа боловч дөнгөж 1 нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Орлого буурснаар байгууллага хоорондын зээлийн сүлжээ үүссэн, халдварын эрсдэлээс болгоомжилж байгаа, хүний нөөцийн хомстол үүссэн зэрэг шалтгаанаар ресторонууд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. Цар тахлын хязгаарлалтын арга хэмжээ нь рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлсөн тухайд тодруулахад давхардсан тоогоор 75% нь бараа, материал, түүхий эдийн үнэ өссөн, 37.5% нь үйлчилгээний эрэлт буурсан мөн 37.5% нь зээл татвар түрээсийн төлбөрийн өр үүссэн болон хүний нөөцийн хомсдолд орсон зэрэг нөлөөллийг нэрлэсэн байна. (Зураг 1.) Бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн тухайд групп ярилцлагаар тодруулахад хил гаалийн хүндрэлтэй холбоотойгоор тээврийн зардлын өсөлт, хүнсний болон бусад бараа бүтээгдэхүүний хомстол нь рестораны бизнес эрхлэгчдийн хувьд хүнсний бараа бүтээгдэхүүн, жижиг хэрэглэл, түүхий эдтэй холбогдох зардлыг их хэмжээгээр өсгөн, хамгийн том хүндрэл үүсгэж байгаа тухай онцолсон юм.

Зураг 1. Ковид-19-ээс сэргийлэх, хөл хорионы хязгаарлалтын арга хэмжээний бизнест үзүүлсэн нөлөө




Орлогын нөлөө

Цар тахлын нөлөөгөөр хэвийн түвшин ба 2019 онтой харьцуулахад 2020 онд судалгаанд оролцсон рестораны аж ахуйн нэгжүүдийн 6 аж ахуйн нэгжийн орлого буурсан байсан бол 2021 онд бүх 8 рестораны орлого буурсан байна.

Орлогын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн тухайд тодруулахад хэвийн түвшинтэй (2019 онтой) харьцуулахад 2020 онд 50%-иар буурсан бол 2021 онд 51%-иар буурч, 2020-2021 онд цар тахлын нөлөөгөөр орлогын хэмжээ 50.6%-иар буурсан байна. (Зураг 2).


Зураг 2. Орлогын буурсан хэмжээ (2020-2021 он)



Ажлын байрны нөлөө


Судалгаанд оролцсон рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчиндээ хэрхэн өөрчлөлт оруулсан тухай тодруулахад 87.5% нь ямар нэгэн байдлаар ажлын байрны тоог бууруулсан бол давхардсан тоогоор 25% нь ажлын цагийг бууруулсан, 12.5% нь цаашид ажлын байрны тоог бууруулна гэжээ. Ажлын байрны тоог хэрхэн бууруулсан тухайд 12.5% нь 30% хүртэлх ажлын байрны тоог бууруулсан бол 62.5% нь ажлын байрны тоогоо 31-80% бууруулсан, 12.5% нь 80%-аас дээш хэмжээгээр бууруулсан ба дунджаар нийт судалгаанд оролцсон 8 рестораны хувьд ажлын байрны тоог **51%-иар** ба **293** ажлын байрыг цомхотгоод байна гэжээ. (Зураг 3)

Зураг 3. Цар тахлаас үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан ажлын байрны тоонд орсон өөрчлөлт



Рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч байгаа бэрхшээлийг тодруулахад давхардсан тоогоор 87.5% нь орлого буурсан, 62.5% нь үнийн өсөлтийн нөлөөгөөр цалин нэмэх, цар тахлаас шалтгаалан хамгаалах хэрэгслээр хангах зэргээр ажиллах хүчтэй холбоотой зардал өссөн гэжээ. (Зураг 4)

Зураг 4. Ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч буй бэрхшээлүүд



Цаашид ажлын байраа хадгалж үлдэхэд шаардлагатай дэмжлэгүүдийг тодруулахад 75% нь ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг, 50% нь НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах, 25% нь хөнгөлөлттэй зээл олгох болон төрийн халамжийн бодлогыг бизнесийн ажил эрхлэлттэй уялдуулах зэргийг анхаарах хэрэгтэй гэсэн байна. (Зураг 5)


Түүнчлэн групп ярилцлагаар эдгээр асуудлуудыг тодруулахад цар тахлын нөлөөгөөр хүнийн нөөцтэй холбогдох зардал өссөн бөгөөд төрийн зүгээс оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн болон төрийн халамжийн бодлогыг бизнесийн салбаруудын ажил эрхлэлттэй уялдуулсан бодлого, журам боловсруулснаар шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

Зураг 5. Ажлын байраа хадгалж үлдэхэд төрөөс шаардлагатай дэмжлэгүүд



Ажлын байраа хадгалахад шаардагдах дэмжлэгийг аж ахуйн нэгжийн ажиллагсдын тооны бүлгээр ангилан авч үзвэл бүлгийн ялгаагүйгээр төрөөс ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг хэрэгтэй гэж үзсэн байна. Мөн бусад дэмжлэгийн хувьд 51-200 ажилтантай аж ахуйн нэгжид НДШ, ХАОАТ-ийн төлбөрийг хойшлуулах чухал бол 11-50 ажилтантай аж ахуй нэгжүүдийн хувьд хөнгөлөлттэй зээл олгох, мөн НДШ, ХАОАТ-ийн төлбөрийг хойшлуулах нь чухал байна. (Зураг 6)


Зураг 6. Ажлын байр хадгалж үлдэхэд шаардлагатай дэмжлэгүүд, ажилчдын тооны бүлгээр



Санхүүжилт


Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүл 62.5% бизнесийн үйл ажиллагааг сэргээхэд санхүүжилт, зээл авах хэрэгцээтэй байгаа бол 12.5% нь нөхцөл байдал тодорхойгүй байгаа учир хэлж мэдэхгүй байна, 25% нь одоохондоо зээл авах хэрэгцээ байхгүй гэжээ. Зээл, санхүүжилт хэрэгцээтэй байгаа аж ахуйн нэгжүүдээс цаашид ямар эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байгааг тодруулахад 38% нь банкны бизнесийн зээл, мөн 38% нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг нэрлэсэн байна. (Зураг 7)

Зураг 7. Үйл ажиллагааг сэргээхэд санхүүжүүлж байгаа (эсвэл санхүүжүүлэх төлөвлөгөөтэй) эх үүсвэрүүд



Цаашид эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөр хэрэгжүүлбэл давхардсан тоогоор 87.5% нь зээлийн нөхцөл, шаардлагыг тухайн салбарын онцлогт тохируулах, 75% нь зээлийн хугацааг нэмэгдүүлэх, 62.5% нь барьцаа хөрөнгийн шаардлага дээр дэмжлэг үзүүлэх зэргийг онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзжээ. (Зураг 8)

Зураг 8. Эдийн засгийг сэргээх, тодорхой салбарыг дэмжсэн зээлийн хөтөлбөрт анхаарах шаардлагатай асуудлууд



Рестораны бизнес эрхлэгчдээс шаардлагатай санхүүжилтээ авч чадвал ямар зориулалтаар зарцуулах тухай тодруулахад 75% нь салбартаа үйл ажиллагаа өргөжүүлэхэд, 37.5 % шинэ ажлын байр бий болгох, 25% ажилтны цалин хөлс болон зээлийн хүүгээ төлөх зэрэгт зарцуулна гэжээ. (Зураг 9)


Зураг 9. Хэрэгцээт санхүүжилтийн зарцуулалт



Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх тухай хүлээлт

Рестораны бизнес эрхлэгчдээс хэзээ үйл ажиллагаа хэвийн ба 2019 онтой ижил түвшинд хүрэх тухай хүлээлттэй байгааг тодруулахад 25% нь ирэх 4-6 сарын хугацаанд, 50% нь ирэх 6-12 сарын хугацаанд гэсэн бол 25% нь нэг жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрнэ гэж таамаглаж байн гэжээ. (Зураг 10)

Зураг 10. Үйл ажиллагаа хэвийн түвшинд хүрэх хүлээлтийн хугацаа



Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл, шаардлагатай дэмжлэгүүд

Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэл

Бизнесээ тасралтгүй явуулахад рестораны бизнест үүсээд буй хүндрэлийг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 75% түүхий эд, бараа материалын үнийн өсөлт, 50% нь хуримтлагдсан татварын өр төлөлт, 35.7% нь үл хөдлөх хөрөнгийн татвар төлөлт зэрэг асуудлууд хамгийн гол хүндрэлийг үүсгээд байна гэжээ. (Зураг 11)

Зураг 11. Бизнесээ тасралтгүй явуулахад тулгарч буй хүндрэлүүд



Засгийн газрын дэмжлэгт хамрагдсан байдал болон цаашид шаардагдах дэмжлэгүүд

Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг авсан тухайд судалгаанд оролцсон бүх аж ахуйн нэгжүүд ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээнд хамрагдсан бол, 87.5% нь НДШ-ийн хөнгөлөлт, 75% нь ажлын байраа хадгалсан ААН-н ажилтанд дэмжлэг үзүүлэх /3 сарын хугацаанд сар бүр 200 мян.төг олгох/, 25% нь Засгийн газрын 3 хувийн зээлд хамрагдсан гэжээ. (Зураг 12)

Зураг 12. Засгийн газраас авсан дэмжлэгүүд



Цаашид бизнесээ сэргээж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байгааг тодруулахад нийт судалгаанд оролцсон рестораны бизнес эрхлэгчдийн 75% нь ус, цахилгаан, дулааны төлбөр, хөнгөлөх чөлөөлөх арга хэмжээний хэрэгжих хугацааг 2022 он дуустал сунгах, 50% нь ААН-ийн албан татвар, НДШ-ийг хойшлуулах, хөнгөлөх гэсэн бол 37.5% нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 25% нь бизнесийг сэргээж хэвийн явуулахад төр нэгдсэн зохицуулалт хийх, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэжээ. (Зураг 13)

Зураг 13. Цаашид бизнесээ сэргээхэд төрөөс шаардлагатай дэмжлэг, арга хэмжээнүүд

